



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

БАЯЛГИЙН САН

НЭГЖ ЭРХ
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ

2025

САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ЗАХИДАЛ

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч танаа

Өнгөрөгч 2024 онд дэлхий дахинд хөрөнгийн зах зээл сэргэж, олон улсын томоохон индексүүд өсөлттэй тэр дундаа АНУ-н SP&500 индекс 23 орчим хувиар, Монголын ТОП-20 индекс 23.7 хувийн өсөлтийг үзүүлж түүхэн дээд түвшиндээ хүрсэн жил боллоо.

2024 онд бид нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаа болон тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд шат дараатайгаар хөрөнгө оруулалтаа хийж ажиллаа.

2025 онд бид бид дотоод зах зээлээс гадна гадаад зах зээл дахь хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах, цаашид цэвэр хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэх, арилжааны хувьд орох эргэлтийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллахыг зорьж байна.

Бидэнтэй итгэн хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулалтын өгөөжөө хүртэж буй хөрөнгө оруулагч та бүхэндээ талархал илэрхийлье.

Сангийн менежер

Т.Батбаяр

АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ
АСУУДАЛ
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ
ХУРЛЫН ЗАР
САНГИЙН ТАНИЛЦУУЛГА
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
ТӨЛӨӨЛӨН УДИДАХ ЗӨВЛӨЛ
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ
САНГИЙН ЗАРДАЛ
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ
АУДИТЫН ТАЙЛАН
ХАВСРАЛТ 1: САНАЛЫН ХУУДАС
ХАВСРАЛТ 2: ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Зарласан нэгж эрх
3 сая ширхэг

Гаргасан нэгж эрх
2.1 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
1,684

Нэгж эрхийн хаалтын ханш
₮1,180.00

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮2.48 тэрбум

Нэгж эрхийн нэрлэсэн үнэ
₮1,000

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН
БАЛГУУЛГАА

Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Сүхбаатар-2, Сентрал тауэр
17 давхар
И-мэйл: info@ardmanagement.mn

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 25/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн хурал
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны №64 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн зохицуулалтыг тус тус үндэслэн “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

“Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашил “Хурал” гэх)- 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар, Криптос ресторан хаягт уралдуулсугай.

1. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийгэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөр тогтоосугай.
3. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн албан ёсны вэб хуудас <https://ardmanagement.mn/> болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн дотор нийгэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулсугай.
5. Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2025 оны 3 дугаар сарын 24-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй нэгж эрх эзэмшигчдийн Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлдчийн хугацааг 2025 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
7. Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Applikeйшн болон цаасан хэлбэрээр хослуулан авсугай.

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

8. Хурлын даргаар “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбууг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбуу;
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Сангийн менежер У.Сүхдарь;
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Сангийн менежер Т.Батбаяр;
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Тооллогын комиссын дарга:
Ө. Бямбагэрэл
Хуулийн зөвлөх
Ард Секюритиз ҮЦК ХХК
 - Тооллогын комиссын гишүүд:
Ч.Даваацэрэн
Санхүүгийн шинжээч
Ард Секюритиз ҮЦК ХХК
А.Эрхбилгүүн
Хөрөнгө оруулалтын зөвлөх
Ард Секюритиз ҮЦК ХХК
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Ард Менежмент ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбууд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн
№25/03 тоот тогтоолын Хавсралт 1

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан
2. 2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ дүгнэлтийг батлах
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан
4. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах
7. Кастодиан үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 3 сарын 14-ний өдрийн
№25/03 тоот тогтоолын Хавсралт 2

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

(Хурал 15:00 цагт эхэлж 17:00 цагт дуусах)

№	Дэд хэсэг	
1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/;	14:50-15:20
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/;	
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;	15:20-15:30
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал хураалт явуулах;	15:20-15:30
5	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт	15:30-16:20
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах;	16:20-16:35
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах;	16:35-16:45
8	Хурлыг хаах	16:45-16:50

**"ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН" ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

"Хөрөнгө Оруулагч Үндэстэн" Хамтын ХОС-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 14-ний өдрийн тогтоолоор Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ГАЗАР: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Централ тауэр, 17 давхар, Криптос ресторан;

ХУГАЦАА: 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт

КОМПАНИЙН ОНООСОН НЭР: "ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН" ХАМТЫН ХОС
ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан
2. 2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ дүгнэлтийг батлах
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан
4. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах
7. Кастодиан үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
2. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
3. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон нэгж эрх эзэмшигч нь Ээлжит хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба та ажлын өдрүүдэд 9:00–18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн талбай-2, Централ Таур, 17 давхарт байрлах "Ард Секюритиз ҮЦК" ХХК-аар дамжуулан хэлэлцэх асуудалд саналын хуудсаар урьдчилан санал өгөх боломжтой.

Саналын хуудсыг урьдчилан хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цаг байна.

Доорх мэдээллийн дагуу хандаж Ээлжит хурлын материал, саналын хуудастай танилцана уу.

№	Байгууллагын нэр	Утас	Шуудангийн хаяг
1	Ард Секюритиз ҮЦК ХХК	(976) 7707 8181	info@ardsecurities.com
2	Ард Менежмент ҮЦК ХХК	(976) 7707 8282	info@ardmanagement.mn
3	Ард Менежмент ҮЦК ХХК	(976) 8911 4432	batbayar.t@ardmanagement.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Баялгийн сан

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм. Бид Монгол Улсын болон дэлхийн хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийн, түүнээс бий болох өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа хүргэхээр зорин ажиллаж байна.

Нэр	Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх
Хугацаа	Үүсгэн байгуулагдсан хугацаа: 2022-04-13 Үйл ажиллагаа явуулах хугацаа: 10 жил
Сангийн татан төвлөрүүлсэн хөрөнгө	3,000,000,000 төгрөг
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Ард Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө хадгалах компани	“Хаан Банк” ХХК-ийн кастодиан банкны хэлтэс
Холбоо барих	- Утас: 976-11-70078080 - И-мэйл: info@ardmanagement.mn - Вэб сайт: www.ardmanagement.mn

САНГИЙН ЗОРИЛГО

Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг дотоодын төдийгүй олон улсын зах зээл дээрх нээлттэй хувьцаат компанийн хувьцаа, бонд болон бусад хөрөнгө оруулалтын хэрэгсэлд мэргэжлийн түвшинд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгө оруулагчдадаа өндөр өгөөж хүртээхийг зорин ажилладаг.

- Дунд хугацаанд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа, бондод хөрөнгө оруулалт хийж өгөөж хүртэх.
- Мөнгөн урсгал, хөрвөх чадварыг тогтвортой байлгаж, эрсдэлийг бага байлгахын тулд засгийн газрын үнэт цаас, компанийн бонд, банкны хадгаламж зэрэг тогтмол орлоготой хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийн өгөөж хүртэх.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Сан нь тэнцвэржүүлсэн буюу хувьцаа, тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигтээ тусгасан. Сангийн зорилго, хөрөнгө оруулалт хийх хэрэгсэл, түүнд тавих хязгаарлалт, Сангийн хөрөнгөд тавигдах шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалт хийдэг. Сан нь ийнхүү хөрөнгө оруулалт хийхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээ, хөрвөх чадварын эрсдэлийн үнэлгээ зэрэг мэргэжлийн суурь шинжилгээ, судалгаанд үндэслэдэг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй санхүү банк, эдийн засаг олон улсын харилцааны чиглэлээр мэргэжлээрээ олон жил ажилласан туршлагатай хамт олноос бүрдэж байна.

Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирддаг менежментийн компани болох Ард Менежмент компани нь Монгол улсдаа хамгийн анхны хамтын санг үүсгэн байгуулж өдгөө 5 жилийн хугацаанд амжилттай удирдаж буй хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.

Ард Менежмент компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022, 2023 оны компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлангийн үнэлгээнд нийт 36 Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас 2 жил дараалан топ-5-д орж засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр тэргүүлэгч компаниар шалгарсан. Компанийн засаглалын кодекс нь компанийн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулахад нэн чухал ойлголт ба хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг багтаадаг байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



ТУЗ-ийн дарга

Чулуун Ганхуяг

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн ТУЗ-ийн дарга

Мэргэжил: Банк санхүү, Эдийн засаг

Чулууны Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлсэн тэрээр 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг төгссөний дараа Монголбанканд хянан шалгагчаар ажилласан. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежер, 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан Гүйцэтгэх Захирлаар нь томилогдсон. ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан түүхтэй. Ч.Ганхуяг нь ХасБанкийг байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх Захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх Захирлын албан тушаал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдын албанд томилогдон тус тус ажиллаж байв. Ч.Ганхуяг нь Банк, санхүүгийн зах зээлд 34 дахь жилдээ ажиллаж байна.



ТУЗ-ийн ердийн гишүүн

Батбилэгийн Золбоо

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Санхүү, Эдийн засаг

Б.Золбоо нь Ард Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх Захирлаар ажилладаг. Өмнө нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал, Ард Менежмент ХХК-ийн Үйл Ажиллагаа Хариуцсан Захирлын албан тушаалыг хашиж байсан. Тэрээр Платсбург хотын Нью-Йорк Мужийн их сургуульд санхүү эдийн засаг суралцан шинжлэх ухааны бакалаврын зэргийг 2016 онд Сумма Кум Лаудэ хүндэт өргөмжлөлтэйгөөр дүүргэж, ажил мэргэжлийн гараагаа Ард Секюритиз ҮЦК-д санхүүгийн шинжээчээр эхэлсэн болно. Тэрээр 2015 онд J.P. Morgan-ий харьяа компани болох Primary Insight, FINRA итгэмжлэгдсэн брокерын Darwood Associates зэрэг компаниудад дадлагажуулах хөтөлбөрүүд, туршлага судлах болон ажилд бэлтгэх сургалтуудад хамрагдсан.



ТУЗ-ийн ердийн гишүүн

Ч Хандаа

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Эдийн засагч

Ч.Хандаа нь 2005 онд МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд 2006 оноос эхлэн одоогийн “Ард Секьюритиз ҮЦК” ХХК-д ажиллаж эхэлсэн. Ажиллах хугацаандаа 2006-2010 онд брокер, дилер, 2010-2012 онд хөрөнгийн зах зээлийн хэлтсийн захирал, 2012 оноос гүйцэтгэх захирлаар тус тус ажилласан. 2015 оноос 2024 оныг хүртэл “Ард Менежмент ҮЦК” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Ч.Хандаа нь 2018 оноос “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажлыг удирдаж амжилттай хэрэгжүүлсэн бол 2022 онд Хөрөнгө Оруулагч Үндэстэн санг үүсгэн байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг удирдан амжилттай хэрэгжүүлсэн байна. Ч.Хандаа нь хөрөнгийн зах зээл, компанийн үнэлгээ, андеррайтер, судалгаа, шинжилгээ, санхүүгийн менежер зэрэг чиглэлүүдээр мэргэшсэн туршлагатай бөгөөд хөрөнгийн зах зээлд нийт 18 жил ажиллаж байгаа.



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Д. Эрдэнэхүү

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Олон улсын харилцаа

Д.Эрдэнэхүү нь 2006 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг нефтийн инженер мэргэжлээр, 2007 онд Монгол Улсын Их Сургуулийг олон улсын худалдаа мэргэжлээр тус тус төгссөн. Ажлын туршлагын хувьд 2010-2013 оны хооронд “МИАТ” ХК-д засварчин, 2011 оноос одоог хүртэл “Маэгнифай” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Я. Чойжилсүрэн

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Санхүүгийн менежер, эрх зүйч

Я.Чойжилсүрэн нь 1993 ХААДС-г геодези зураг зүйн мэргэжлээр төсгөж улмаар 2005 Мандах бүртгэл ДС-ийн Бизнесийн удирдлага, 2010 МУИС Хууль зүйн сургууль, эрх зүйч мэргэжлээр төгссөн тэрээр 2005 Сэргэн Мандалт Групп ХХК-д санхүүгийн менежер 2007 Мөнхийн Үсэг Групп ХХК-д ахлах нягтлан бодогч хийж байгаад 2009 оноос Амардаатгал ХХК Гүйцэтгэх захирал 2009-одоо хүртэл Кэй Эйч Кэй ХХК-д Ерөнхий нягтлан бодогч

Мөн 2019-одоо г хүртэл Амардаатгал ХХК, Санхүүгийн газрын захирлын албыг хашиж буй санхүү хөрөнгийн зах зээл дээр олон жил ажиллаж буй туршлагатай мэргэжилтэн юм.

Сангийн менежер



Т. Батбаяр

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн менежер

Мэргэжил: Санхүүгийн менежер

Т.Батбаяр нь 2020 онд СЭЗИС-г санхүү менежмент мэргэжлээр төгссөн. 2021-2024 онд Ард Секюритиз ҮЦК ХХК-д брокер, дотоод арилжааны дилер, 2024 оноос Ард Менежмент ҮЦК ХХК-д сангийн менежерээр ажиллаж байна.



НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2022 оны 9-р сарын 20-ны өдөр эхэлсэн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 911 нэгж эрх эзэмшигч 3,000,000 ширхэг нэгж эрхийг авч байсан бол 2024 оны эцсийн байдлаар нийт 1,684 нэгж эрх эзэмшигчтэй, нэгж эрхийн тоо 2,100,934 болсон байна.


	Нэгж эрхийн тоо	Хувь
Ард Кредит ХК	420,532	20.0%
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	257,501	12.3%
Богд Банк ХК	250,000	11.9%
Амар Даатгал ХХК	150,000	7.1%
Ард Даатгал ХК	150,000	7.1%
Бусад жижиг*	872,901	41.5%
Нийт	2,100,934	100.0%

*5 хувиас бага эзэмшлийн хувь бүхий нэгж эрх эзэмшигчдийг нэгтгэн харуулсан.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сан нь 2022 оны 10-р сард үйл ажиллагаагаа эхэлсэн ба Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллалаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2024 эцсийн байдлаар ₮2.4 тэрбумд хүрч нэгж эрхийн үнэлгээ үүсгэн байгуулагдсан цагаас хойш ₮1,000-өөс ₮1,180 болж 18%-иар өслөө.

Сангийн нэгж эрхийн үнэлгээний өөрчлөлт (2022-2024)




	2022.10.17	2022.12.31	2023.12.30	2024.12.31
Нэгж эрхийн үнэлгээ	1,000	1,043	1,007	1,180.00
Нэгж эрхийн тоо	3,000,000	2,372,374	2,372,523	2,100,934

Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн хөрөнгө оруулалтын багц нь Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй 17 компанийн хувьцаа, 7 төрлийн тогтмол орлоготой үнэт цаас, хадгаламж, бэлэн мөнгөнөөс бүрдэж байна. Хөрөнгө Оруулалтын багцыг хөрөнгө оруулалтын бодлогын дагуу бүрдүүлж ажилласан.


САНГИЙН АКТИВЫН БҮТЭЦ



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Үйл ажиллагаа явуулж буй 2 жил хагасын хугацаанд хадгаламж дахь хөрөнгийг хувьцаа болон тогтмол орлоготой үнэт цаас, гадаад зах зээлийн хөрөнгө оруулалтын бэлтгэлийг хангаж, бэлэн мөнгийг боломжит бага түвшинд барьж ажилласан.


Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЗАРДАЛ

Зардлын нийт дүн нь 127 сая төгрөг, Үүнээс ХОМК-ийн зардал нийт зардлын 56 сая төгрөг, Кастодиан банкны зардал 3 сая төгрөг, бусад зардал 68 сая төгрөгийн зардлууд тус тус гарсан байна.



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Хөрөнгө Оруулагч Үндэстэн сан нь хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ сандаа хүссэн үедээ буцаан арилжаалах боломжтой байдаг бөгөөд энэ нь сангийн нэгж эрхийг зах зээл дээрх хамгийн өндөр хөрвөх чадвартай бүтээгдэхүүн болгодог.

Тайлант хугацаанд нийт 0.9 тэрбум төгрөгийн нэгж эрхийн арилжаа хийгдсэн байна.

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2025 оны 2 сарын 12-ны өдөр эчнээ санал хураалт явуулж, 2024 оны үр дүнгээс ногдол ашиг тараахгүй байх шийдвэр гаргалаа. ХОҮС-ийн орлого хуваарилах тухай бодлого, журамд заасны дагуу ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг сангийн санхүүгийн нөхцөл байдал, хөрвөх чадварын үзүүлэлтүүдийг харгалзан шийдвэрлэсэн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 онд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сангийн ТУЗ нийт 6 удаа ээлжит хурал, эчнээ санал хураалт явуулж, хууль, сангийн дүрэм, дотоод дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Хамтын ХОС нь 2024 оны эцсийн байдлаар 356 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

ОРЛОГЫН ТАЙЛАН (сая төгрөг)

Үзүүлэлт	2023 Q4 Аудит	2024 Q4 Аудит
Хүүгийн орлого	131	78
Бусад орлого	35	102
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	(111)	305
Нийт орлого	55	485
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(58)	(56)
Кастодианы үйлчилгээний зардал	(7)	(3)
Бусад зардал	(66)	(68)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн цэвэр гарз	0.5	0
Нийт үйл ажиллагааны зардал	(131)	(127)
Татварын өмнөх ашиг	(75)	358
Татварын зардал	(10)	2
Тайлант үеийн цэвэр ашиг	(86)	356

САНХҮҮГИЙН ТАЙЛАН (сая төгрөг)

Үзүүлэлт	2023 Q4 Аудит	2024 Q4 Аудит
Нийт хөрөнгө	2,400	2,548
Мөнгө	50	213
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	2,193	2,190
Авлага	25	9
Урьдчилж төлсөн төлбөр	132	136
Нийт өр төлбөр	8	69
Бусад өглөг	8	69
Хойшлогдсон татварын өр		
Эздийн өмчийн дүн	2,392	2,479
Өмч	2,358	2,089
Хуримтлагдсан ашиг	34	390

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Ард Менежмент ҮЦК ХХК-ийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан

Ард Менежмент ҮЦК ХХК (цаашид “Ард Менежмент” гэх) нь өндөр өгөөжтэй, ирээдүйд хурдтай өсөх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Ард Менежмент нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, 2016 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх болсон.

Ард Менежмент нь 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр ХОҮС-тай 22/05 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулсан. Энэхүү гэрээний дагуу Сангийн менежер Т.Батбаяр нь Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 онд Ард Менежмент компаниас ХОҮС-д доорх үйлчилгээг үзүүлсэн байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдах

- Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн хувьд 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар 2.4 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгийн үнэлгээтэйгээр хаагдлаа. Харин нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 1,163.62 төгрөгийн үнэлгээтэй буюу үүсгэн байгуулагдсан цагаас хойш(2022 оны 10-р сар) нэгж эрхэд ногдох өсөлт 163.62 төгрөг байна.

Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах:

- Сангийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайланг гаргаж хүргүүлэв.
- Сангийн тайлан мэдээнүүдийг гаргаж, тайлагнахтай холбоотой Хаан Банкны кастодиан банк, МХБ, СЗХ зэрэгтэй хамтарч ажиллаж, МХБ болон Ард Менежментийн цахим сайтуудад Сангийн нэгж эрхийн арилжаа, хөрөнгө оруулалтын талаар тогтмол мэдээг хүргэв.
- “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” сангийн нэгж эрхийн арилжааг зохион байгуулах, нэгж эрх худалдан авах, худалдах зэрэг үйл ажиллагааг ажлын өдрүүдийн 10:00-аас 12:30 цагийн хооронд явуулан ажиллаж байна.
- Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах:

“Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХОС нь тайлант хугацаанд ТУЗ-ийн нийт 6 удаагийн хурал, эчнээ санал хураалтыг зохион байгуулав.

2. 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, ХОҮС-ийн дүрмийн хүрээнд доорх дүгнэлтийг гаргаса:

Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн төлөөлөн удирдах зөвлөл 2024 онд нийт 6 удахурал, эчнээ санал хураалт явуулсан ба эдгээр хурлаар:

- 2024 оны үйл ажиллагаа болон улирал, хагас жилийн санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэх,
- Хөрөнгө Оруулалтын бодлого, цаашдын төлөвлөгөөг хэлэлцэх,
- Нэгж эрх эзэмшигчдийн хурал болон түүгээр хэлэлцэх асуудал батлах,
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах зэрэг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, ХОС-ийн дүрмийн хүрээнд доорх дүгнэлтийг гаргасан болно.

Хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын дагуу ХОҮС нь хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, 2024 оны эцсийн байдлаар нэг нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 1,163.62 төгрөгт хүрсэн байна.

Гүйцэтгэх удирдлага нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт болон бусад дотоод хууль журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж тухай бүр дор дурдсан мэдээллүүд, тайлангуудыг хүргэж ажилласан байна. Үүнд:

Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.

- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх

Иймд гүйцэтгэх удирдлагын багийг Монгол улсын хамгийн анхны нээлттэй ХОС-ийн үйл ажиллагааг хууль журмын дагуу удирдаж ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Мөн цаашид хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан төлөвлөсөн өгөөждөө хүрч ажиллахыг Сангийн менежер болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож байна.

3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан

ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан холбогдох журамд заасны дагуу ХААН Кастодиан нь (цаашид “Кастодиан” гэх) “Хөрөнгө оруулагч үндэстэн хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)-тай 2022 оны 4 сарын 28-ны өдөр байгуулж, 2023 оны 7 сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан ба “Хөрөнгө Хадгалах Гэрээ”-ний дагуу Санд үзүүлсэн үйлчилгээ болон 2024 оны сангийн багцын гүйцэтгэлийн талаар тусгасан жилийн тайланг бэлтгэлээ. Хөрөнгө оруулалтын багцын тайланг хавсаргав.

ХААН БАНКНЫ КАСТОДИАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

ХААН Банк нь 2016 оноос кастодианы үйлчилгээг үзүүлж эхэлсэн бөгөөд гадаад, дотоодын харилцагчдад Монголын хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бүрдүүлэхийг зорьж ажилладаг. Кастодианы хадгалалтад одоогоор дараах төрлийн хөрөнгүүд байна: Гадаад/Дотоод нээлттэй хувьцаа

- Гадаад/Дотоод нээлттэй хувьцаа
- Засгийн газрын үнэт цаас
- ХХК-ийн хувьцаа
- Орон нутгийн бонд,
- Хамтын ХОС-ийн нэгж эрх
- Биржийн бус зах зээлийн өрийн хэрэгслүүд
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)
- Үл хөдлөх хөрөнгө

Кастодиан банкны Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үзүүлэх үйлчилгээнүүд:

- Үнэт цаас хадгалалт
- Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо
- Компанийн үйл ажиллагаа
- Тайлагнал
- Чөлөөт мөнгөний удирдлага
- Зах зээлийн мэдээ, судалгаа
- Нэгж эрхийн тухайлсан бүртгэл
- Цэвэр хөрөнгийн үнэлгээ

ХААН Кастодиан нь харилцагчдынхаа сэтгэл ханамжид нийцүүлэн, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхийн тулд үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж, шинэ боломжуудыг эрэлхийлж ажиллаж байна. 2024 онд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна:

- Дотоод системд хөгжүүлэлт хийн арилжааны тайлан хүлээн авах, нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг автоматаар илгээх боломжтой болсон,
- Татварын тухай хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд нэгж эрх эзэмшигчдийн арилжааны ашгаас албан татвар суутгаж эхэлсэн,
- Санхүүгийн зохицуулах хорооны Кастодианы үйл ажиллагааны журам, Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх журам болон Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журмуудад саналаа хүргүүлсэн,
- Биржийн бус зах зээлийн системтэй холболт хийж харилцагчийн оруулсан үнэт цаасыг хадгалах, төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой болсон

КАСТОДИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Кастодиан нь 2024 онд “Хөрөнгө Хадгалах Гэрээ”-ний дагуу дараах үйлчилгээг Санд үзүүлсэн байна. Үүнд:

1. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тухайлсан бүртгэлийг өдөр бүр хөтлөх, тайлан илгээх,
2. Сан өрийн хэрэгсэл арилжаалах үед хуримтлагдсан хүүгийн тооцоололт хяналт тавьж, хүү болон үндсэн төлбөр төлөгдөхөд эргэн төлөлтийг хуваарийн дагуу хянаж, орлогыг хүлээн авах,
3. Сангийн багц дахь хувьцааны ногдол ашиг хүлээн авах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын зар хүргүүлэх, үнэт цаас гаргагчийн тендер оффериин зар хүргүүлэх, эдгээрт холбогдуулан авах арга хэмжээ, даалгаврыг Сангийн менежерээс авч ажилласан.
4. Үнэт цаасны төлбөр тооцоо болон мөнгөн хөрөнгийн шилжүүлэг.
5. Тайлагнал
 - Цэвэр хөрөнгийн үнэлгээний тооцоолол, багцын гүйцэтгэлийн тайлан (өдөр бүр)
 - Нэгж эрхийн тухайлсан бүртгэлийн тайлан (өдөр бүр)
 - Мөнгөн хөрөнгийн дансны хуулга (сар бүр)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

2024 оны жилийн эцсийн байдлаар Сангийн багцын 70.31%-ийг нээлттэй хувьцаа, 13.70%-ийг бирж нээлттэй арилжаалагддаг ХБҮЦ болон компанийн бонд, 7.21%-ийг хугацаат хадгаламж, 8.78%-ийг мөнгөн хөрөнгө бүрдүүлж байна.

Сангийн хөрөнгө оруулсан хувьцаанаас жилийн хугацаанд ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа хамгийн өндөр буюу 183.54%-ийн өсөлттэй, мөн Голомт Банк ХК, Таван Толгой ХК, ХасБанк ХК, Монложистик Холдинг ХК, Улаансан ХК зэрэг компаниудын үнэлгээ өссөн үзүүлэлттэй байна.

Сангийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг Ариг банканд байршуулсан хугацаат хадгаламж, Хаан банк болон Богд Банк дахь харилцахын үлдэгдэл бүрдүүлж байна.

ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТ

Хязгаарлалт	Үзүүлэлт
Нээлттэй арилжаалагддаг компанийн хувьцаа хөрөнгө оруулалт нийт багцын 70 хувиас дээшгүй байна	70.31%
Үнэт цаас, бонд, банкны хадгаламж болон бэлэн мөнгөний хөрөнгө оруулалт нийт багцын 30 хувиас дээш байна	29.69%
Эдийн засгийн нэг салбарт хийх хөрөнгө оруулалт нийт багцын 25 хувиас дээшгүй байна	Санхүү – 46% Бусад салбар: 2%-11%
Нэг компаниас эзэмших хувьцааны хэмжээ нь нийт багцын 10 хувиас дээшгүй байна	LEND – 11.5% Бусад хувьцаа: 0.68%-8638%

ЦХҮ ТООЦООЛОЛ БОЛОН НЭГ ЭРХИЙН БҮРТГЭЛ

2024 онд Сангийн нэгж эрх эзэмшигчид өмнөх онтой харьцуулахад 56.22%-иар нэмэгдлээ. Сан нь хөрөнгө оруулалтын багцын өгөөжийг удирдаж цэвэр хөрөнгийн үнэлгээг 17.41%-иар өсгөсөн.

Кастодиан нь Сангийн нэгж эрхэд ногдох ЦХҮ-ний тооцоололд хяналт тавих үүргийнхээ хүрээнд Сангийн санхүүгийн бүртгэлийг хөтөлж, цэвэр хөрөнгийн үнэлгээг давхар тооцоолдог.

КАСТОДИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ, ХУРААМЖ

Кастодиан нь Санд үзүүлсэн үйлчилгээний шимтгэл, хураамжийг улирлаар тооцож суутгадаг. 2024 онд Кастодианы үйлчилгээний шимтгэл хураамж нийт 7,557,984.94 төгрөг байсан байна.

4. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Хөрөнгө оруулагч үндэстэн хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид “Хөрөнгө оруулагч үндэстэн хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК (цаашид “Компани” гэх)–ийн 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АОУС–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН ХАМТЫН ХОС ХХК

2024 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2024	2023
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	14	77,837	130,973
Ногдол ашгийн орлого	15	90,915	6,604
Бусад орлого	16	7,722	28,357
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бусад цэвэр өөрчлөлт		305,901	(111,059)
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз / (гарз)		3,242	417
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз / (гарз)		-	-
Нийт орлого/ (Зардал)		485,617	55,292
ХОМК-ийн үйлчилгээний зардал	17	(55,947)	(57,801)
Кастодианы үйлчилгээний зардал	17	(3,231)	(7,353)
Бусад зардал	17	(68,286)	(66,241)
Гадаад валютын ханшийн зөрүүний цэвэр гарз		-	509
Нийт үйл ажиллагааны зардал		(127,464)	(130,886)
Татварын өмнөх ашиг / (алдагдал)		358,153	(75,594)
Орлогын албан татварын зардал	18	(2,457)	(10,226)
Тайлант жилийн ашиг		355,696	(85,820)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (төгрөгөөр)	12		(36.27)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН ХАМТЫН ХОС ХХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2024-12-31	2023-12-31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Дансны болон бусад авлага	8	8,825	25,450
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	9	1,696,892	1,563,961
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	9	493,050	628,807
Урьдчилж төлсөн төлбөр	10	136,404	132,414
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	11	212,881	49,524
Нийт хөрөнгө		2,548,052	2,400,156
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өглөг	13	69,110	8,283
Нийт богино хугацаат өр төлбөр		69,110	8,283
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг	18	-	-
Нийт урт хугацаат өр төлбөр		-	-
Нийт өр төлбөр		69,110	8,283
ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	12	2,089,295	2,357,922
Хуримтлагдсан ашиг		389,647	33,951
Нийт цэвэр хөрөнгө		2,478,942	2,391,873
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө		2,548,052	2,400,156

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН ХАМТЫН ХОС ХХК

2024 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,387,710	103,346	2,491,056
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	16,425	16,425
2023 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,387,710	119,771	2,507,481
Тайлант жилийн ашиг	-	(85,820)	(85,820)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант жилд гаргасан нэгж эрх	945,894	-	945,894
Буцаан татсан нэгж эрх	(975,682)	-	(975,682)
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,357,922	33,951	2,391,873
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,357,922	33,951	2,391,873
Тайлант жилийн ашиг	-	355,696	355,696
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант жилд гаргасан нэгж эрх	259,703	-	259,703
Буцаан татсан нэгж эрх	(528,330)	-	(528,330)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,089,295	389,647	2,478,942

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь 2023 оны ээлжит нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр сонгогдсон ба 2025 онд 2 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байна. Үүнтэй холбоотойгоор сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр сонгохоор нэр дэвшигчдийн мэдээллийг оруулж байна.

ТУЗ-д нэр дэвшигчдийн мэдээлэл:

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид		
1	Чулуун овогтой Ганхуяг	Мэргэжил: Эдийн засагч, санхүүч Албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга Ажилласан жил: 34
2	Батбилэг овогтой Золбоо	Мэргэжил: Эдийн засагч, санхүүч Албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн гүйцэтгэх захирал Ажилласан жил: 8
3	Чадраабал овогтой Даваасамбуу	Мэргэжил: Эдийн засагч, санхүүч Албан тушаал: Ард Менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ажилласан жил: 7
Хараат бус гишүүнд нэр дэвшигчид		
4	Ган-Эрдэнэ овогтой Лхагва- Очир	Мэргэжил: Санхүү, нягтлан бодох бүртгэл Албан тушаал: Стратегийн бизнесийн контроллер Ажилласан жил: 7
5	Цэрэндавааа овогтой Баярмаа	Мэргэжил: Олон улсын тогтвортой байдал Албан тушаал: Гүйцэтгэх захирал, Аурум Ойл ХХК Ажилласан жил: 18
6	Даваабаатар овогтой Эрдэнэхүү	Мэргэжил: Нефтийн инженер, Олон улсын худалдаа Албан тушаал: Гүйцэтгэх захирал, Магнифай ХХК Ажилласан жил: 15

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны 2025 оны зардлын төсвийг доорх бүтэцтэй байхаар санал оруулав.

№	Төсөв	Тоо ширхэг	Давтамж	Нэгж /төгрөг/
1	ТУЗ-ийн даргын цалин урамшуулал	1	4	1,500,000
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал	4	4	800,000
3	ТУЗ-ийн хурлын зардал	1	4	250,000

7. Кастодиан үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Хамтын ХОС-д хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлж буй Хаан Банк ХК-тай байгуулсан Хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж, шинэчлэн батлуулахаар Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оруулав. Хөрөнгө хадгалах гэрээнд доор дурдсан агуулга бүхий холбогдох зохицуулалт, хавсралт маягтын өөрчлөлт орох ба Гэрээний үндсэн тохиролцоо, үнэ зэрэг бусад хэсэгт өөрчлөлт орохгүй:

- 2023 онд ААНОАТХ болон ХХОАТХ хууль, тэдгээрт нийцүүлэн батлагдсан хэм хэмжээний актуудын зохицуулалтын дагуу Кастодианы үйлчилгээ үзүүлэгч нь иргэн, хуулийн этгээдээс татвар суутган тооцох, төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд нэгж эрх эзэмшигчийн ашгийн албан татварыг тайлагнаж, төсөвт төлөхтэй холбогдох зохицуулалт, хавсралт маягтад өөрчлөлт орно.
- Сангийн зардлын гүйлгээг интернэт банкаар дамжуулан хялбар, түргэн шуурхай гүйцэтгэхтэй холбоотой Гэрээний зохицуулалтад өөрчлөлт орох,
- 2024 онд Кастодианы үйл ажиллагааны журам орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Гэрээнд заасан Компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйлчилгээний хэсэгт дэлгэрэнгүй зохицуулалт нэмэх.

САНАЛЫН ХУУДАС



**“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1)**

Нэгж эрх эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй нэгж эрхийн тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар, Криптос ресторанд хуралдах “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн **ээлжит хурал** санал өгнө.

Д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан	Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан батлах тухай				
2	2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ дүгнэлтийг батлах	2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ дүгнэлтийг батлах тухай				
3	Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан	Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах тухай				
4	2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт	2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтийг батлах тухай				
5	Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох		Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/			
	1					
	2					

3					
4					
5					
6					
Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох			Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/		
1					
2					
3					
6	Толоолон удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах	Толоолон удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах тухай			
7	Кастодиан үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	Кастодиан үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдэглэгээг хийнэ үү.
2. Нэгж эрх эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Ард аншлейкшнаар болон Ард Секюритиз Үнэт цаасны компани (ҮЦК) дээр өөрийн биеэр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Санамж: “Хоронго Оруулагч Үндэстэн” хамтын ХОС-ийн дүрэмд заасны дагуу сангийн ТУЗ нь нийт 5 гишүүнтэй байх ба үүнээс 3 гишүүн ердийн, 2 гишүүн хараат бус байхаар тогтоосон. Нэгж эрх эзэмшигч та Толоолон удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох санал өгөхдөө **кумулятив аргаар** санал өгөх ба саналын тоогоо илүү эсвэл буруу өгсөн тохиолдолд таны саналын хуудас хүчингүйд тооцогдох тул доорх заавар жишээтэй сайтар уншиж танилцана уу.

Жишээ: Нэгж эрх эзэмшигч та 100 ишрхэг нэгж эрх эзэмидэг бол ТУЗ-ийн 5 гишүүнийг сонгохоор кумулятив аргаар санал өгөхөд таны 100 нэгж эрх **500 (100*5=500) саналын эрхтэй болно** гэсэн үг. Үүнээс та 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 3 хүртэлх нэр дэвшигчид, 200 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 2 хүртэл тооны нэр дэвшигчид санал өгөх боломжтой. Нэгж эрх эзэмшигч та саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Нэгж эрх эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

ТОГТООЛЫН ТӨСӨЛ



_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн
тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны №64 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэг, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2024 оны жилийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Толоолон Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд
хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны №64 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх хэсэг, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААЛСАМБУУ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Кастодиан банкны хөрөнгө хадгалах
үйлчилгээний жилийн тайланг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны №64 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэг, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хаан банк” ХК-ийн Кастодиан Банкны хэлтсийн хоронго хадгалах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2024 оны жилийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хараат бус аудитын байгууллагын
дүгнэлтийг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны №64 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх хэсэг, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгох тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухайн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны ээлжит нэгж эрх эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүнийг сонгон, томилсугай. Үүнд:

№	Ердийн гишүүдийн нэрс
1	
2	
3	

ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигч:

№	Хараат бус гишүүдийн нэрс
1	
2	

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл
ажиллагааны зардлын төсөв батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухайн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Хавсралт ёсоор баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт даалгасугай

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

№	Төсөв	Тоо ширхэ г	Давтамж	Нэгж /төгрөг/
1	ТУЗ-ийн даргын цалин урамшуулал	1	4	1,500,000
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал	4	4	800,000
3	ТУЗ-ийн хурлын зардал	1	4	250,000

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний
гэрээнд нэмэлт, оорчлолт оруулах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухайн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг болон “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” Хамтын ХОС-ийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хаан Банк” ХК-тай байгуулсан №22/01 тоот “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-нд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулж Хавсралт ёсоор байгуулахыг “Ард Менежмент ҮКЦ” ХХК-д зөвшөөрсүгэй.
2. Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй “Ард Менежмент ҮЦК” ХХК, Сангийн менежер Т.Батбаяр нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

БАЯЛГИЙН САН

Web: <https://ardmanagement.mn>

Facebook: <https://www.facebook.com/ardmanagement>

Instagram: <https://www.instagram.com/ardmanagement>

Mail: info@ardmanagement.mn

Phone: 7700-3322